

БАТЛАВ.
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГА Б.БОЛД-ЭРДЭНЭ

2025 оны 01 сарын 20-ны өдөр

"Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах "
хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
Зорилт 1.Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн дагуу олгох.			
1	Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан цалингийн сүлжээг баримтлан албан хаагчдын албан тушаалын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож олгох.	Сар бүр	Нягтлан бодогч
2	Төрийн үйлчилгээний албан хаагчийн ур чадварын нэмэгдлийг ажлын үр дүнг харгалзан олгох.	Сар бүр	Байгууллагын удирдлага
3	Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт хөдөлмөрийн гэрээг дүгнэж, хууль тогтоомжид заасны дагуу урамшууллын асуудлыг шийдвэрлэх.	Улирал бүр	Байгууллагын удирдлага
4	Албан хаагчдад сар бүр хоол, унааны зардлыг олгох.	Сар бүр	Нягтлан бодогч
5	Албан хаагчдад хуулийн дагуу тусламж олгох.	Тухай бүр	Нягтлан бодогч
6	Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг хамгаалах арга хэмжээ авах.	Тухай бүр	Байгууллагын удирдлага
Зорилт 2: Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөл боломжоор хангах			
7	Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бичгийн хэрэгсэл, ширээ, сандал, компьютер, принтер, сканнер, хувилагч болон бусад техник хэрэгслэлээр хангах.	Жилийн турш	Нягтлан бодогч
8	Албан үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай үед унаагаар хангах.	Тухай бүр	Байгууллагын удирдлага
Зорилт 3: Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлэх.			
9	Төрийн албан хаагчдыг жилд нэг удаа нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах.	1удаа	Байгууллагын удирдлага
Зорилт 4: Амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах.			
10	Эрүүл аж төрөх, чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэхийг дэмжиж идэвхтэй амралт зохион байгуулах.	1 удаа	Ахлах мэргэжилтэн
11	Баяр, тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан байгууллагын ажилтнуудын дунд үдэшлэг, уулзалтыг зохион байгуулах.	Тухай бүр	Ахлах мэргэжилтэн